

Агуулга

1.	Аудитын гэрчилгээ	2
2.	Аудитын тайлан	4
2.1.	Оршил	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8.	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9.	Зорилтот түвшний талаарх тайлбар, тодруулга	7
2.10.	Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.11.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12.	Шилэн дансны мэдээлэл	9
2.13.	Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14.	Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3.	Менежментийн захидал	10
4.	Аудит хийсэн санхүүгийн тайлан	13
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	13
4.2	Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	14
1.4.	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16
5.	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ХК	Хувьцаат компани
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ М.ГАНБААТАР
ТАНАА

2020.03.13 № 06/878
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Таван толгой түлш ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Таван толгой түлш ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Таван толгой түлш ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Таван толгой түлш ХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Таван толгой түлш ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг Таван толгой түлш ХХК-ийн гүйцэтгэх захирал М.Ганбаатар Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах, бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас авах авлагыг барагдуулах, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Таван толгой түлш ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Таван толгой түлш ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Таван толгой түлш ХХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдрөөс, 2020 оны 3 дугаар сарын 13-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 3 дугаар сарын 16-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Сүлд-Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Таван толгой түлш ХХК нь 2019 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 01/123 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Таван толгой түлш ХХК нь 2019 оны санхүүгийн тайланг засварлан Сүлд-Аудит ХХ-д 2020 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 01/208 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Таван толгой түлш ХХК-ийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь чанарыг эрхэмлэн, хямд үнэ өртөг бүхий бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн зах зээлд нийлүүлэхийн зэрэгцээ агаарын бохирдлыг бууруулахад бодитой хувь нэмрээ оруулахад орших болон Нийслэлийн гэр хорооллын айл өрхийг сайжруулсан шахмал түлшээр хангаж агаарын бохирдлыг бууруулан ажиллахад оршино.

Таван толгой түлш ХХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Шахмал түлшний үйлдвэрлэл
- Гадаад дотоод худалдаа

Тайлант хугацаанд компанийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”
- Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмэгдүүлсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон.

Монгол улсын Засгийн газар “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг 2017 онд баталж хөтөлбөрийн хүрээнд авах арга хэмжээ, хүрэх үр дүнг 2025 он хүртэл тодорхойлсон. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд 2019 оны 05 дугаар сарын 15-аас Улаанбаатар хотод түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон. Тайлант онд Таван толгой түлш ХХК-ийн үйлдвэрлэсэн шахмал түлшээр нийслэлийн гэр хорооллын бүс дэх айл өрхийг хангаснаар агаарын чанар тоосонцорын суурь он болох 2016 оны 12 дугаар сарын дунджаас 2-2.3 дахин буурсан байгаа нь Эко цогц шийдэл ХХК-ийн агаарын бохирдолд хийсэн судалгаагаар нотлогдсон байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллага нь санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулаагүй байна.

Таван толгой түлш ХХК нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “Axplorer” программ хангамж ашигладаг байна.

Таван толгой түлш ХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Таван толгой түлш ХХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 12 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн орлогын дэлгэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Тус байгууллага нь өөрийн шахмал түлшний борлуулалт болон Эрдэнэс таван толгой ХК, Байгаль орчин аялал жуулчлалын яам, Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газраас тус тус санхүүжүүлсэн байна. Тиймээс санхүүжилтийн зарцуулалт нь хэрэглэгчдийн анхаарлыг татах тул зардлыг материаллаг байдлын суурь болгон сонгон авлаа.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,210.2 сая төгрөгөөс тооцон 24.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 852.0 сая төгрөгөөр тогтоосон нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн суурь үзүүлэлтээс тооцсонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Таван толгой түлш ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 103,253.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	8,695.0	6,536.8	(2,158.2)
Авлага	246.9	9,532.5	9,285.6
Бараа материал	1,811.9	44,027.4	42,215.5
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	473.1	780.4	307.3
Үндсэн хөрөнгө	6,975.4	60,474.5	53,499.1
Биет бус хөрөнгө	4.9	108.8	103.9
Нийт хөрөнгийн дүн	18,207.2	121,460.4	103,253.2
Богино хугацаат өр төлбөр	588.7	8,921.1	8,332.4
Урт хугацаат өр төлбөр	18,600.0	130,368.4	111,768.4
Өр төлбөрийн дүн	19,188.7	139,289.5	120,100.8
Өмч: Төрийн	1.0	1.0	-
Хуримтлагдсан ашиг	(982.5)	(17,830.1)	(16,847.6)
Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн	18,207.2	121,460.4	103,253.2

Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгө, урт хугацаат өглөгийн данс материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2,158.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны зорилтот түвшний төлөвлөгөөг биелүүлэхтэй холбоотойгоор бүтээн байгуулалт, үйлдвэрлэл, борлуулалттай холбоотой зардалд өмнөх оны үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 9,285.6 сая төгрөгөөр өссөн нь шахмал түлшний борлуулалтын төлбөр дутуу төлөгдсөн, мөн зорилтот түвшний төлөвлөгөөг биелүүлэхтэй холбоотойгоор шахмал түлшний үйлдвэрлэлийн бүтээн байгуулалт, угсралт суурилуулалт, тоног төхөөрөмж нийлүүлэлтийн гэрээний урьдчилгаа төлбөрүүдийг хийсэн зэргээс шалтгаалжээ. Нийт авлагын дүнд шахмал түлшний борлуулалтын авлага 1,795.1 сая төгрөг, тоног төхөөрөмжийн авлага 2,788.1 сая төгрөг, түүхий эд материалын авлага 4,691.5 сая

төгрөг, толгойтын үйлдвэрийн барилгатай холбоотой авлага 257.8 сая төгрөг тус тус эзэлж байна.

Урьдчилж төлсөн зардал/тооцоо дансны үлдэгдэл 307.3 сая төгрөгөөр өссөн нь үйлдвэрт ашиглагдах тоног төхөөрөмжүүдийн гэрээт ажлын урьдчилгаа төлбөрийг төлснөөс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 42,215.5 сая төгрөгөөр өссөн нь шахмал түлшний түүхий эд материалыг их хэмжээгээр нөөцлөн худалдан авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 53,499.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд үндсэн хөрөнгийн данс 54,287.5 сая төгрөгөөр нэмэгдэж, 788.4 сая төгрөгийн элэгдэл байгуулснаас шалтгаалжээ. Тайлант хугацаанд нэмэгдсэн үндсэн хөрөнгүүдийг тодруулбал; хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу 39,384.4 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, оффисын өргөтгөлтэй холбоотойгоор бараа материал болон авлагын данснаас 5,195.4 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсан, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 434 дугаар тогтоолын дагуу “ДЦС-2 ТӨХК”-с тус байгууллагын бүртгэлд байсан үндсэн хөрөнгүүдийг балансаас балансад 9,707.7 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсан байна.

Биет бус хөрөнгө 103.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь борлуулалт, захиалгын цогц программ болон төсөв удирдлагын программ худалдан авснаас шалтгаалжээ. Тайлант хугацаанд 15.6 сая төгрөгийн хорогдол байгуулжээ.

Богино хугацаат өр төлбөрийн 8,921.1 сая төгрөгийн өглөг нь бэлтгэн нийлүүлэгчдэд төлөх өглөг 6,557.7 сая төгрөг, цалингийн өглөг 6.7 сая төгрөг, татвар болон нийгмийн даатгалд төлөх өглөг 1,347.1 сая төгрөг, урьдчилж орсон орлого 1,009.5 сая төгрөгөөс тус тус бүрдэж байна. Урьдчилж орсон орлого данс нь Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газраас борлуулагчдад олгох урамшууллын орлого болон борлуулагч нарын барьцааны орлого тусгагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдлийн 93.2 хувийг буюу 111,768.4 сая төгрөгийг урт хугацаат өр төлбөр болох Эрдэнэс таван толгой ХК-ийн санхүүжилтийн өглөг эзэлж байна.

Тайлант хугацаанд 16,847.5 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж хуримтлагдсан алдагдал 17,830.0 сая төгрөгт хүрчээ.

2.9. Зорилтот түвшний талаарх тайлбар, тодруулга

Таван толгой түлш ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 18 дугаар тогтоолоор тухайн байгууллагын 2019 оны зорилтот түвшний төлөвлөгөөг баталсан байна.

Таван толгой түлш ХХК-ийн удирдлагад чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь 2019 онд 185,732.5 сая төгрөгийн зардлын төсвийг баталсан байна. Батлагдсан зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрт тайлант оны борлуулалтын орлого болон бусад санхүүжилтээс 177,037.5 сая төгрөгийг бүрдүүлэхээр, 8,695.0 сая төгрөгийг өмнөх оны санхүүжилтийн үлдэгдлээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Тайлант оны шахмал түлшний орлогоос 48,817.4 сая, Байгаль орчин аялал жуулчлалын яамны санхүүжилтээс 14,053.8 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхээр, Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газраас агаарын бохирдлыг бууруулах зорилгоор борлуулагч нарт олгож буй урамшуулалд 2,398.0 сая төгрөг, санхүүжүүлэхээр, эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр Эрдэнэс таван толгой ХК-аас хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтад 111,768.3 сая төгрөг нийт 177,037.5 сая төгрөгийн орлого, санхүүжилтээс бүрдэж байна.

2019 онд шахмал түлшний борлуулалтын хэмжээг анх 325 мянган тонн түлш борлуулахаар төлөвлөсөн боловч Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газраас агаарын бохирдлыг бууруулах, утааг багасгахын тулд айл өрхөд 7 хоногт 6 ширхэг 25 кг-ийн

шуудайтай түлш авах, сайн карт уншуулах гэх мэт хязгаарлалтуудыг тогтоож өгснөөр борлуулалтын орлого төлөвлөгөөнд хүрээгүй байна.

Зардлын хувьд шахмал түлшний борлуулалтаас орж ирсэн санхүүжилтийг өөрийн үйл ажиллагаа болон үйлдвэрлэлийн сав, баглаа боодлын зардалд зарцуулж төлөвлөснөөс 30,205.9 сая төгрөгөөр дутуу зарцуулсан байна. Байгаль орчин аялал жуулчлалын яамны санхүүжилтийг нөөцийн агуулах, борлуулалтын цэгийн саравчны засвар тохижилтод зарцуулан 1,253.8 сая төгрөгөөр, Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газраас орж ирсэн санхүүжилтийг борлуулагч нарын урамшуулалд зарцуулан 742.6 сая төгрөг тус тус дутуу зарцуулсан байна. Нийтдээ орсон орлого, санхүүжилтээс 32,202.3 сая төгрөг хэмнэгджээ.

Тайлант хугацаанд 16,847.5 сая төгрөгийн алдагдалтай нь шахмал түлшний борлуулалт төлөвлөсөн хэмжээнд хүрээгүйгээс шалтгаалжээ.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 12 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 10 эрсдэл тодорхойлж нийт 22 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 11,167.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 10,644.2 сая төгрөгийн алдааг залруулж, 8.2 сая төгрөгийн 1 зөрчилд акт тогтоож, 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 514.6 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 зөвлөмж өглөө. Үүнээс:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд 8.2 сая төгрөгийн цалинг илүү тооцоолж олгосон байгаа нь Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн өмчит оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журмын “3.7. Энэ журмын 3.6-д заасан цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна.” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчилд акт тогтоов

2. Тухайн байгууллага нь нийт 457 цэгээр дамжуулан шахмал түлшээ борлуулдаг байна. Борлуулалтын цэгийн борлуулагч нар нь 2.0 сая төгрөгийн барьцаа байршуулдаг бөгөөд барьцаа хөрөнгөнөөс илүү хэмжээний шахмал түлшийг зээлээр олгохгүй байхаар борлуулагчийн гэрээнд тусгасан байна. Гэвч тайлант онд Улаанбаатар хотыг шахмал түлшээр таслахгүйн тулд борлуулагчдад барьцаанаас илүү хэмжээгээр шахмал түлшийг зээлээр олгосон байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1² –д “*Үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн “20.2.5 дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”-д заасантай нийцэхгүй байна. Энэ нь эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

Залруулагдаагүй 514.6 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Улсын онцгой байдал зарласан цаг үе болон цаг хугацааны хязгаарлагдмал байдал зэргээс шалтгаалан худалдан авах ажиллагааны тендерийн хуулийн хэрэгжилт, төлөөлөн

удирдах зөвлөлийн тогтоол шийдвэрийн талаар, авлага өглөгийн тулган баталгаажуулалт, борлуулалтын цэгүүдэд биет горим хэрэгжүүлээгүй болно. Дээрх асуудлуудыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Таван толгой түлш ХХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 4 мэдээллийг хуулийн хугацаанд нь байршуулж ажилласан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжих шатандаа зөвлөмжийн хэрэгжилт 83 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Таван толгой түлш ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд, аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Зөрчилгүй дүгнэлт

Залруулагдаагүй 522.8 сая төгрөгийн алдаа, зөрчлийн дүн бидний тогтоосон 852.0 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй санал дүгнэлт өгч байна.

Таван толгой түлш ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн зөв, бодитой, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Тус байгууллага нь санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулаагүй байна. Энэ нь "...Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж мөрдөх..." гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв, бодитой оршин байх, хэмжилт, үнэлгээ батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, холбогдох журам, зааврыг хэрэгжүүлж ажиллаагүй байх;

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн дансны жишиг жагсаалтыг шинэчлэх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2 Бараа материалын данстай холбоотой асуудал

3.2.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд Энержи ресурс ХХК-иас үнэ төлбөргүйгээр авсан 706,382 тонн угаасан нүүрсний өртгийг тээвэрлэлтийн хөлсөөр тооцож түүхий эд материалын шууд материалын өртөгт шингээсэн байна. Энэ нь НББОУС 2 "Бараа материал 12 дугаар зүйл" болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т зааснаар "Үнэн зөв байх" гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал, хэмжилт ба үнэлгээ гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3.2.2. Эрсдэл:

Түүхий эд материалын өртөг буруу тодорхойлогдох;

3.2.3. Өгсөн зөвлөмж:

Тээвэрлэлтийн хөлсийг үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлын өртөгт бүртгэх.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.3 Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

3.3.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд гарсан худалдан авалтын ажил гүйлгээнээс түүвэрлэн авч үзэхэд нийт 34.1 сая төгрөгийн худалдан авалтыг баримтын бүрдэл дутуу гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3.2. Эрсдэл:

Хууль журам хэрэгжихгүй байх;

3.3.3. Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахгүй байх.

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.4 Өглөгийн данстай холбоотой асуудал

3.4.1. Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд тусгагдсан нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг нь нийгмийн даатгалын байгууллагаар баталгаажсан 12 дугаар сарын нийгмийн даатгалын тайлангийн үлдэгдлээс 400.2 сая төгрөгөөр илүү тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т зааснаар "Үнэн зөв байх" гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3.4.2. Эрсдэл:

Буруу тайлагнагдсан байх;

3.4.3. Өгсөн зөвлөмж:

Ажилчдаас суутгасан нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн тайлагнах.

3.4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.5 Татварын өглөгийн данстай холбоотой асуудал

3.5.1 Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд тусгагдсан татварын үлдэгдлийн дүнг татварын тодорхойлолттой тулган шалгахад аж ахуйн нэгжийн татварын өглөг 8.9 сая төгрөгөөр илүү, хувь хүний орлогын албан татварын өглөгийн дүн 70.5 сая төгрөгөөр илүү тайлагнагджээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т зааснаар "Үнэн зөв байх" гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3.5.2 Эрсдэл:

Буруу тайлагнагдсан байх;

3.5.3 Өгсөн зөвлөмж:

Татварын албатай тооцоо нийлэн татварын үлдэгдлийг залруулах.

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.6 Татварын хөнгөлөлттэй холбоотой асуудал

3.6.1. Илрүүлэлт:

2019 оны жилийн эцэст хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийн тооцооллыг нэгтгэж тооцоолоогүйгээс зарим ажилчдад нийт дүнгээрээ 0.1 сая төгрөгийн хөнгөлөлтийг дутуу, заримд нь 0.8 сая төгрөгийн хөнгөлөлтийг илүү эдлүүлсэн байгаа нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн “24.1 Энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн албан татварт албан татварын хөнгөлөлт үзүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.6.2. Эрсдэл:

Татварын тооцоолол буруу гарах

3.6.3. Өгсөн зөвлөмж:

Татварын хуулийг хэрэгжүүлж ажиллах , алдааг залруулах

3.6.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	8,695,021,339.42	6,536,835,093.42
1.1.2	Дансны авлага	237,186,145.12	7,556,738,520.39
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага		
1.1.4	Бусад авлага	9,697,087.00	1,975,699,871.30
1.1.5	Бараа материал	1,811,945,486.81	44,027,386,983.64
1.1.6	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	473,053,412.32	780,432,172.32
1.1.7	Эргэлтийн хөрөнгийн дүн	11,226,903,470.67	60,877,092,641.07
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	6,975,438,749.51	60,474,499,588.33
1.2.2	Биет бус хөрөнгө	4,882,777.78	108,808,333.37
1.2.3	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.4	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.5	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	6,980,321,527.29	60,583,307,921.70
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	18,207,224,997.96	121,460,400,562.77
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	575,065,299.50	6,557,687,472.29
2.1.1.2	Цалингийн өглөг		6,699,870.00
2.1.1.3	Татварын өр	13,685,170.67	921,051,668.74
2.1.1.4	НДШ - ийн өглөг		426,122,186.82
2.1.1.5	Банкны богино хугацаат зээл		
2.1.1.6	Бусад богино хугацаат өр		
2.1.1.7	Урьдчилж орсон орлого		1,009,536,442.13
2.1.1.8	Бусад өглөг		
2.1.1.9	Богино хугацаат өр төлбөрийн дүн	588,750,470.17	8,921,097,639.98
2.1.1.10	Урт хугацаат өр төлбөр	18,600,000,000.00	130,368,360,000.00
2.1.1.11	Урт хугацаат зээл		
2.1.1.12	Нөөц өр төлбөр		
2.1.1.13	Бусад урт хугацаат өр төлбөр	18,600,000,000.00	130,368,360,000.00
2.1.2	Урт хугацаат өр төлбөрийн дүн	19,188,750,470.17	139,289,457,639.98
2.2	Өр төлбөрийн нийт дүн		
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: Төрийн	1,000,000.00	1,000,000.00
2.3.2	Хувийн		
2.3.3	Хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.6	Хуримтлагдсан ашиг	(982,525,472.21)	(17,830,057,077.21)
2.3.7	Эздийн өмчийн дүн	(981,525,472.21)	(17,829,057,077.21)
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	18,207,224,997.96	121,460,400,562.77

4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	33,300,749.99	25,174,452,863.03
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	36,599,096.64	25,303,872,305.18
3	Нийт ашиг (алдагдал)	(3,298,346.65)	(129,419,442.15)
4	Түрээсийн орлого	490,000.00	
5	Хүүний орлого	89,272,886.40	442,060,506.83
6	Ногдол ашгийн орлого		
7	Бусад орлого	141,254,830.00	25,522,157,706.99
8	Борлуулалт, маркетингийн зардал		2,248,971,762.98
9	Ерөнхий ба удирдлагын зардал	1,201,317,553.32	39,308,732,626.90
10	Санхүүгийн зардал		411,538,058.57
11	Бусад зардал		668,881,877.54
13	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
14	Бусад ашиг (алдагдал)		
15	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(973,598,183.57)	(16,803,325,554.32)
16	Орлогын татварын зардал	8,927,288.64	44,206,050.68
17	Татвар дараах ашиг (алдагдал)	(982,525,472.21)	(16,847,531,605.00)
18	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
19	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(982,525,472.21)	(16,847,531,605.00)
20	Бусад дэлгэрэнгүй орлого		
20.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
20.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
20.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	(982,525,472.21)	(16,847,531,605.00)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн	24,755,330.00	39,161,547,778.21
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	24,265,330.00	22,151,588,300.00
1.1.2	Буцаан авсан албан татвар		
1.1.3	Бусад мөнгөн орлого	490,000.00	17,009,959,478.21
1.2	Мөнгөн зарлагын дүн	3,290,609,192.48	114,034,203,271.13
1.2.1	Ажиллагчдад төлсөн	649,476,849.70	14,526,786,731.85
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	150,927,827.56	3,770,894,869.47
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,704,579,457.20	83,642,912,143.64
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	138,632,929.75	1,922,881,417.16
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	43,401,780.00	2,432,184,685.45
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	68,646,812.93	563,553,674.99
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		83,203,848.57
1.2.9	Бусад мөнгөн зарлага	534,943,535.34	7,091,785,900.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(3,265,853,862.48)	(74,872,655,492.92)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн	89,272,686.40	442,060,506.83
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого		
2.1.2	Хүлээн авсан ноогдол ашиг		
2.1.3	Хүлээн авсан хүүний орлого	89,272,686.40	442,060,506.83
2.2	Мөнгөн зарлагын дүн	6,729,397,484.50	39,495,951,259.91
2.2.1	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.2	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	6,724,227,484.50	39,384,391,259.91
2.2.3	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	5,170,000.00	111,560,000.00
2.2.4	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(6,640,124,798.10)	(39,053,890,753.08)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн	18,600,000,000.00	111,768,360,000.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	18,600,000,000.00	111,768,360,000.00
3.1.2	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг		
3.2	Мөнгөн зарлагын дүн		
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.2.2	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал		
3.2.3	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	18,600,000,000.00	111,768,360,000.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	8,694,021,339.42	(2,158,186,246.00)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,000,000.00	8,695,021,339.42
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,695,021,339.42	6,536,835,093.42

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Нийт дүн
1	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,000,000.00			1,000,000.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,000,000.00			1,000,000.00
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
6	Өмчид гарсан өөрчлөлт				
7	Тайлант үеийн үр дүн			(982,525,472.21)	(982,525,472.21)
9	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,000,000.00		(982,525,472.21)	(981,525,472.21)
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
13	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
15	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
16	Тайлант үеийн үр дүн			(16,847,531,605.00)	(16,847,531,605.00)
17	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,000,000.00		(17,830,057,077.21)	(17,829,057,077.21)

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:

2020.03.19

Аудитын
нэр:2019 оны Санхүүгийн
тайлангийн аудит

Аудитын код:

САГ-2020/87/СТА-ТӨҮГ

Шалгагдсан
байгууллагын нэр:

Таван толгой түлш ХХК

сая төгрөгөөр

Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
		Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5
Таван толгой түлш ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд 8.2 сая төгрөгийн цалинг илүү тооцоолж олгосон.	8.2	Акт тогтоох	Гүйцэтгэх захирал	М.Ганбаантар
Тус байгууллага нь санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулаагүй байна.	0.0	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	П.Амарцэцэг
Тухайн байгууллага нь нийт 457 цэгээр дамжуулан шахмал түлшээ борлуулж байна. Борлуулалтын цэгийн борлуулагч нар нь 2.0 сая төгрөгийн барьцаа байршуулдаг бөгөөд барьцаа хөрөнгөнөөс илүү хэмжээний шахмал түлшийг зээлээр олгохгүй гэсэн борлуулагчийн гэрээтэй. Гэвч тайлант онд Улаанбаатар хотыг шахмал түлшээр таслахгүйн тулд борлуулагчдад барьцаанаас илүү хэмжээгээр шахмал түлшийг зээлээр олгожээ.	0.0	Албан шаардлага хүргүүлэх	Ерөнхий нягтлан бодогч	П.Амарцэцэг
Тайлант хугацаанд Энержи ресурс ХХК-иас үнэ төлбөргүйгээр авсан 706,382.38 тонн угаасан нүүрсний өртгийг тээвэрлэлтийн хөлсөөр тооцож түүхий эд материалын өртөгт шингээсэн байна.	0.0	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	П.Амарцэцэг
Тайлант хугацаанд гарсан худалдан авалтын ажил гүйлгээнээс түүвэрлэн авч үзэхэд нийт 34.1 сая төгрөгийн худалдан авалтыг баримтын бүрдэл дутуу буюу төлбөрийн баримтгүйгээр хийжээ.	34.1	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал	М.Ганбаантар
Санхүүгийн тайланд тусгагдсан нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг дансны үлдэгдлийг 12 дугаар сарын нийгмийн даатгалын тайлангийн үлдэгдэлтэй тулган шалгахад 400.2 сая төгрөгөөр илүү тайлагнагдсан байна.	400.2	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	П.Амарцэцэг

Санхүүгийн тайланд тусгагдсан татварын үлдэгдлийн дүнг татварын тодорхойлолттой тулган шалгахад аж ахуйн нэгжийн татварын өглөг 8.9 сая төгрөгөөр илүү, хувь хүний орлогын албан татварын өглөгийн дүн 70.5 сая төгрөгөөр илүү тайлагнагджээ.	79.4	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	П.Амарцэцэг
2019 оны жилийн эцэст хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийн тооцооллыг нэгтгэж тооцоолоогүйгээс зарим ажилчдад нийт дүнгээрээ 0.1 сая төгрөгийн хөнгөлөлтийг дутуу, заримд нь 0.8 сая төгрөгийн хөнгөлөлтийг илүү эдлүүлсэн.	0.9	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	П.Амарцэцэг
Дүн	522.8			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 24

№ 02/156

Улаанбаатар хот

СЭТ. 2020/37/СТА ТӨЧГ
Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Таван толгой түлш ХХК-ийн санхүүгийн тайлангийн аудитын явцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тухайн байгууллага нь нийт 457 цэгээр дамжуулан шахмал түлшээ борлуулж байна. Борлуулалтын цэгийн борлуулагч нар нь 2.0 сая төгрөгийн барьцаа байршуулдаг бөгөөд барьцаа хөрөнгөнөөс илүү хэмжээний шахмал түлшийг зээлээр олгохгүй байхаар борлуулагчийн гэрээнд тусгасан байна. Гэвч тайлант онд Улаанбаатар хотыг шахмал түлшээр таслахгүйн тулд борлуулагчдад барьцаанаас илүү хэмжээгээр шахмал түлшийг зээлээр олгосон байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 –д “Үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”-д заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах акт тавих, зөрчлийг арилгах албан шаардлага өгөх ...”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, журмыг мөрдөж ажиллах, зөрчлийг таслан зогсоох, цаашид давтан гаргахгүй байх
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Таван толгой түлш ХХК-ийн гүйцэтгэх захирал М.Ганбаатар, ерөнхий нягтлан бодогч П.Амарцэцэг нарт даалгав.

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТОР Л.МӨНХЦАЦРАЛ
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:

СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ
Ч.ГҮНДБАЯР

АЛБАН ШААРДЛАГА

ЗӨВШӨӨРСӨН:

ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ ХК -ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

М.ГАНБААТАР
НЯГТЛАН БОДОГЧ

П.АМАРЦЭЦЭГ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүрүүлнэ” гэж заасны дагуу харууцагч албан тушаалтанд харууцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүрүүлнэ.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2020 оны 03 дугаар сарын 24

№ 02/72

СЭГ- 2020/87/СТЯ-ТӨЧГ

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Таван толгой түлш ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Таван толгой түлш ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд 8.2 сая төгрөгийн цалинг илүү тооцоолж олгосон байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн өмчит оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журмын 3.7." Энэ журмын 3.6-д заасан цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна." гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх..." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1-д ...заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Илүү олгогдсон 8,160,000.00 төгрөгийн цалинг буруутай албан тушаалтнаар төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Улсын төсвийн орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Таван толгой түлш ХХК-ийн гүйцэтгэх захирал М.Ганбаатар, ерөнхий нягтлан бодогч П.Амарцэцэг нарт даалгав.

АКТ

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР
Л.МӨНХЦАЦРАЛ

СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ч.ГҮНДБАЯР

ЗӨВШӨӨРСӨН:

ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
М.ГАНБААТАР

НЯГТЛАН БОДОГЧ

П.АМАРЦЭЦЭГ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Richie_Kheree\Akt\2020\0324SAG1.Docx

001090193

